

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ АРВАНДОЛДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны тавдугаар сарын 19 -ны 14 цаг 15 минутад эхэлж, 15 цаг 07 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 52 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Сангийн яамны зарим албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай</p> <ul style="list-style-type: none">- Төсвийн хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар- Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн:</p> <p>Анягийн Мөнхбаясгаланг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн:</p> <p>1.Бадамхатаны Гантулга,</p>

		<p>Юндэнбазарын Нэргүй нарыг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх</p> <p>2.Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт нэр заагдан нөөцөд бүртгэгдсэн иргэн Бадамхатаны Гантулгыг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтод санал болгох тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Говь-Алтай, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Говь-Алтай аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар 2016 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 1/598 тоот албан бичгээр Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга Төрийн албаны зөвлөлд 2016 оны 5 дугаар сарын 06-нд ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 6 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв.</p> <p>Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд тавигдаж байгаа шаардлага хэт доогуур байгаа тул уг ажлын байрыг нийтэд, нээлттэйгээр зарлах боломжгүй хэмээн шийдвэрлэлээ.</p>
3	<p>Өмнөговь, Хөвсгөл, Завхан аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ</p>

	<p>нөхөх мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2016 оны 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд Өмнөговь аймаг, Хөвсгөл аймаг, Завхан аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 62 иргэн /Өмнөговь аймагт 3, Хөвсгөл аймагт 49, Завхан аймагт 10/-ийг "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д, 4, 5 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 49 иргэн /Хөвсгөл аймагт 42, Завхан аймагт 7/-ийг "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 6, 7, 8 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 13 /Өмнөговь аймагт 2, Хөвсгөл аймагт 8, Завхан аймагт 3/-ийг, "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 9, 10 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 6 иргэн /Хөвсгөл аймагт 5, Завхан аймагт 1/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 6-10 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий</p>
--	---------------------------------------	---

		<p>19 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөл /Б.Түвшинбаяр/-д, Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөл /Г.Төмөрбаатар/-д, Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөл /Д.Түвшинжаргал/д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монголын Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА